



УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ТОГТООЛ

1970. оны 8 дугаар
сарын 14. -ны өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЗАРИМ
СУРГУУЛЬ, СУРАГЧДЫГ ШИЛЖҮҮЛЖ
ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ**

Ерөнхий боловсролын зарим сургуулиудын байршил, анги дүүргэлт, шинэ барилга ашиглалтанд орж байгааг харгалзан Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргаанаас ТОГТООХ нь:

1. 54-р бага сургуулийн сурагчдыг нутаг дэвсгэрийн байршилаар Төв аймгийн Баянцогт сумын дунд сургуульд, 16-р дунд сургуулийн сурагчдыг 4-р сургуульд, 31, 37-р сургуулийн сурагчдыг УП хорооллын шинэ сургуульд тус тус түс шилжүүлж 74-р сургуулийг 16-р дунд сургууль гэж нэрлэсүгэй.

2. 16-р сургуулийн байранд 3-р дунд сургуулийн дэргэдэх оройн сургуулийг шилжүүлэн ээлжийн сургууль болгон өргөтгөж хичээллүүлсүгэй.

3. Дээрхи сургуулийн сурагчдыг шилжүүлж хичээллүүлэх, багш нарын хөдөлгөөнийг зохицуулах, эд аж ахуйг бусад сургуулиудад балансаар шилжүүлэн өгөхийг Хотын ардын боловсролын хэйтэс /н.Бат-өлзийт/, Сүхбаатар, Октябрыйн районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.Чакерхаан, н.Гунгаажав/ нарт даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ДАРГА

С.МОНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАТАЙ НАРИИН
БИЧГИЙН ДАРГА

Ч.ЖАМБАЛ
Ч.Жамбал